



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Отгон сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/053/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2025 он

Дарга,
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarH@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 90088028 Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул
Утас: 91195554 Цахим хаяг: tuul9565@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

┌ ОТГОН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ┐
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Д.ЦЭДЭНСОДНОМ-Д

2025.08.11 № 69

танай _____-ны № _____-т

┌ Өөрчлөлтгүй дүгнэлт ┐

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Отгон сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Отгон сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогоор 773.1 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн орлогоор 33.1 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэн үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Отгон сумын Эрүүл мэндийн төв нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасныг зөрчин 13.7 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр зарцуулсан зөрчил илэрлээ.

Бусад асуудлын хэсэг

2024 оны жилийн эцэст 572.6 сая төгрөгийн хөрөнгийн тооллогыг холбогдох журмын дагуу хийж гүйцэтгээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт-2025

812502054

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *Д.Бат-Ундраа* Д.БАТ-УНДРАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****2023 оны 12 дугаар сарын 31****/төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,433.0	112,773.4
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3,481.3	
8	Банканд байгаа бэлэн мөнгө	3,481.3	
17	Төрийн сангийн харилцах	3,481.3	
27	АВЛАГА	6,123.9	46,693.0
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	175.8	561.3
29	Татаас санхүүжилтийн авлага	3,948.1	44,131.7
34	Бусад авлага	2,000.0	2,000.0
60	БАРАА МАТЕРИАЛ	31,827.8	66,080.3
61	Түүхий эд материал	243.6	243.6
63	Эм боох материал	243.6	243.6
66	Хангамжийн материал	31,584.3	65,836.7
67	Бичиг хэргийн материал	292.4	432.4
68	Аж ахуйн материал	11,341.6	38,319.0
71	Барилгын засварын материал	480.0	2,664.0
72	Хүнсний материал	1,057.0	2,686.0
73	Бусад хангамжийн материал	18,413.2	21,755.2
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	418,528.7	506,614.6
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	418,528.7	506,614.6
108	Биет хөрөнгө	411,834.7	499,920.6
109	Барилга, байгууламж	293,414.4	293,414.4
110	Хуримтлагдсан элэгдэл	-30,838.8	-36,706.2
111	Авто тээврийн хэрэгсэл	142,853.7	160,843.4
112	Хуримтлагдсан элэгдэл	-80,657.2	-28,920.7
113	Машин, тоног төхөөрөмж	190,976.0	238,477.9
114	Хуримтлагдсан элэгдэл	-106,595.5	-129,328.1
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,902.0	20,177.0
116	Хуримтлагдсан элэгдэл	-17,846.7	-18,495.4
122	Бусад үндсэн хөрөнгө	2,827.2	2,827.2
123	Хуримтлагдсан элэгдэл	-2,658.7	-2,827.2
127	Программ хангамж	895.0	895.0
128	Хасагдуулаг	-895.0	-895.0
129	Бусад биет бус хөрөнгө	6,694.0	6,694.0
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	459,961.7	619,387.9
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	459,961.7	619,387.9
215	Засгийн газрын хувь оролцоо	459,961.7	619,387.9
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	443,267.4	443,267.4
217	Өмч: -Төрийн өмч	443,267.4	443,267.4
223	Хуримтлагдсан үр дүн	-8,239.4	151,096.7
224	Өмнөх үеийн үр дүн	-8,329.4	-8,329.4
225	Тайлант үеийн үр дүн		159,426.1

227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,023.6	25,023.6
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	459,961.7	619,387.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	690,520.0	1,073,208.3
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,388.9	226,689.5
77	Нийтлэг татварын бус орлого	73,388.9	226,689.5
140020	Бусад орлого	4,197.9	6,000.00
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	69,190.9	220,689.5
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	617,131.0	846,518.7
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс		
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутаг /	31,406.2	33,159.5
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас	585,724.8	813,359.2
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	707,207.2	866,349.4
148	УРСГАЛ ЗАРДАЛ	707,207.2	866,349.4
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	707,207.2	866,349.4
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	413,784.5	581,417.3
151	Цалин	209,381.6	304,539.6
152	Нэмэгдэл цалин	119,044.5	184,981.4
153	Унаа хоолны хөнгөлөлт	4,517.9	15,055.00
154	Урамшуулал	80,840.3	76,841.1
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,612.3	81,335.7
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	39,856.3	55,184.8
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,689.0	6,537.7
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,751.2	3,268.9
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	937.8	3,268.9
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	9,378.0	13,075.4
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,953.5	30,133.5
165	Гэрэл цахилгааны зардал	2,165.9	2,798.5
166	Түлш, халаалтын зардал	25,787.5	27,335.0
167	Цэвэр, бохир усны зардал		
170	Хангамж, бараа материалын зардал	38,990.8	31,937.1
171	Бичиг хэргийн материал	2,157.0	981.5
172	Тээвэр, шатахууны зардал	26,165.3	26,080.4
173	Шуудан холбоо интернэтийн төлбөр	1,980.0	1,764.6
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	593.0	510.0
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	270.0	2,600.6
178	Аж ахуйн материал худалдан авах зардал	7,825.5	
181	Нормативд зардал	85,999.6	56,368.4
182	Эм	74,980.0	49,669.6
183	Хоол	6,419.6	6,198.8
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,600.0	500.0

185	Эд хогшил, урсгал засварын зардал	20,934.7	18,646.3
188	Багаж хэрэгсэл	106.0	
189	Урсгал засвар	20,828.7	18,646.3
190	Томилолт, зочны зардал	10,198.3	8,114.5
192	Дотоод томилолтын зардал	10,198.3	8,114.5
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,425.4	1,485.3
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		354.3
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,080.0	540.0
198	Тээврийн хэрэгслийн татвар	42.5	
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	143.0	371.1
201	Газрын төлбөр	72.5	72.5
209	Бараа үйлчилгээний бусад зардал	6,490.0	3,260.4
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,817.7	53,280.2
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		370.3
228	Төвлөрүүлэх шилжүүлэг		344.4
	Төвлөрүүлэх шилжүүлэг		25.9
278	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		47,432.7
288	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)		-47,432.7
289	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)		159,426.1

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	617,831.4	812,335.1
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,498.5	6000.0
78	Нийтлэг татварын бус орлого	4,498.5	6000.0
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутаг /	31,406.2	33,159.5
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	613,332.9	806,335.1
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	581,926.7	773,175.6
144	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	581,926.7	773,175.6
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	581,926.7	773,175.6
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	640,125.1	815,816.4
148	УРСГАЛ ЗАРДАЛ	640,125.1	815,816.4
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	640,125.1	815,816.4
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	413,784.5	581,417.3
151	Үндсэн цалин	209,381.6	304,539.6
152	Нэмэгдэл	119,044.5	1584,981.4
153	Унаа хоолны хөнгөлөлт	4,517.9	15,055.0
154	Үр дүнгийн урамшуулал	80,840.3	76,841.1
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,788.1	814,721.3
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	40,032.1	55,570.4
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,689.0	6,537.7
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,751.2	3,268.9
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	937.8	3,268.9
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	9,378.0	13,75.4
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	28,406.2	30,133.5

165	Гэрэл цахилгааны зардал	2,165.9	2,798.5
166	Тулш, халаалтын зардал	25,787.5	26,795.0
167	Цэвэр, бохир усны зардал	452.7	540.0
170	Хангамж, бараа материалын зардал	35,224.5	32,018.7
171	Бичиг хэрэг	2,075.0	1,121.5
172	Тээвэр, шагахуун	26,165.3	26,080.4
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980.0	1,764.8
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,368.1	760.0
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,636.1	2,292.2
181	Нормативд зардал	55,954.1	51,859.7
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,501.9	43,778.0
183	Хоол, хүнс	6,652.2	7,581.7
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800.0	500.0
185	Эд хогшил, урсгал засварын зардал	26,515.2	20,810.3
186	Багаж техник хэрэгсэл	216.0	
188	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,800.0	
189	Урсгал засвар	24,499.2	20,810.3
190	Томилолт, зочны зардал	9,586.0	8,114.5
192	Дотоод албан томилолт	9,586.0	8,114.5
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,425.4	1,485.2
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж		354.5
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080.0	540.0
198	Тээврийн хэрэгслийн татвар	54.4	
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	143.0	371.1
201	Газрын төлбөр	72.5	72.5
203	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		147.2
	Бараа үйлчилгээний бусад зардал	10,440.9	7,885.2
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		370.3
225	Төвлөрүүлэх шилжүүлэг		344.4
	Төвлөрүүлэх шилжүүлэг		25.9
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		
251	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(I)-(II)	-22,293.6	-3,481.3
252	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
262	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	14,039.0	
263	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,039.0	
264	Дотоод эх үүсвэрээр	14,039.0	
276	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,039.0	
279	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)-(IV)-(V)	-14,039.0	
280	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
304	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-36,332.6	-3,481.3
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,481.3
306	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,481.3	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	443,267.4	25,023.6	8,357.8	476,648.9
10	443,267.4	443,267.4	25,023.6	-16,687.2	-16,687.2
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	443,267.4	25,023.6	-8,357.8	459,961.7
13	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			159,426.1	159,426.2
14	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	443,267.4	25,023.6	151,096.7	619,387.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨ Ө	ГҮЙЦЭТГЭЛ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,481.3	-3,481.3
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	721,662.8	648,378.0
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	721,662.8	648,378.0
4	Бараа, үйлчилгээний зардал	721,662.8	648,378.0
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	617,997.6	545,959.1
6	Үндсэн цалин	330,352.0	290,103.9
7	Нэмэгдэл	252,073.6	180,882.7
8	Унаа, болон бусад нөхөн олговор	6,072.0	15,040.0
9	Урамшуулал	29,500.0	59,992.4
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,2349.8	77249.8
12	Тэтгэврийн даатгал	52,529.8	52,529.8
13	Тэтгэмжийн даатгал	6,180.0	6,180.0
14	ҮОМШӨ ний даатгал	3,090.0	3,090.0
15	Ажилгүйдлийн даатгал	3,090.0	3,090.0
16	Эрүүл мэндийн даатгал	12,360.0	12,360.0
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,133.5	30,133.5
18	Гэрэл цахилгаан	2,798.5	2,798.5
19	Түлш, халаалт	26,795.0	26,795.0
20	Цэвэр, бохир ус	540.0	540.0
22	Хангамж, бараа материалын зардал	2,157.1	2,157.1
23	Бичиг хэрэг	1,357.7	1,121.5
24	Тээвэр (шатахуун)	2,157.1	2,157.1
25	Шуудан холбоо, интернэгийн төлбөр	1,764.6	1,764.6
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,034.0	760.0
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,200.0	912.5
30	Нормативд зардал	30,470.5	39,368.0
31	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,054.3	26,054.3
32	Хоол, хүнс	3,816.2	3,813.7

33	Нормын хувцас зөөлөн эдлэл	600.0	500.0
34	Эд хогшил худалдан авах	4,675.0	3,875.0
35	Багаж, техник, хэрэгсэл		
37	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	800.0	
38	Урсгал засвар	3,875.0	3,875.0
39	Томилолт, зочны зардал	6,226.8	5,850.5
41	Дотоод албан томилолт	6,226.8	5,850.5
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,863.7	1,413.9
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	356.5	354.5
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	540.0	540.0
46	Даатгалын үйлчилгээ	60.0	
47	Тээврийн хэрэгслийн татвар	148.0	
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99.0	
49	Мэдээллийн технологийн зардал	374.4	371.1
50	Газрын төлбөр	150.0	72.5
51	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	75.8	75.8
53	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	818,811.5	773,175.6
70	Бусад урсгал шилжүүлэг	818,811.5	773,175.6
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	818,811.5	773,175.6
106	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	818,811.5	773,175.6
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,481.3
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	21.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00
135	Гүйцэтгэх ажилтан	19.00	18.00
136	Үйлчлэх ажилтан	2.00	2.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Отгон сумын Эрүүл мэндийн төвийн зорилго:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг, чирэгдэлгүй, шуурхай чанартай хүргэж аюулгүй таатай орчныг бүрдүүлсэн сумын жишиг эмнэлэг болох

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Отгон сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль

7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хэрэгжүүлж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг Бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Отгон сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Отгон сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 159,425.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Төрийн сангийн харилцах	3,481.3	0	-3,481.3
Авлага	6,123.9	46,693.0	40,569.1
Бараа материал	31,827.8	66,080.3	34,252.5
Үндсэн хөрөнгө	418,528.7	506,614.6	88,085.9
Нийт хөрөнгө	459,961.7	619,387.9	159,425.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	459,961.7	619,387.9	159,425.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	459,961.7	619,387.9	159,425.2

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,481.3 мянган төгрөгөөр буурсан нь эхний үлдэгдлийг зарцуулсантай холбоотой байна.

Авлагын эхний үлдэгдэл 6,123.9 мянган төгрөг, тайланд онд 46,693.0 мянган төгрөгийн авлага өссөн байна. 52,429.1 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага нэмэгдсэн.

Бараа материалын эхний үлдэгдэл 31,827.8 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 105,482.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 31,890.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүйгээр ирсэн бараа материалыг бүртгэж, 103,120.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар эцсийн үлдэгдэл 66,080.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 34,252.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд хөрөнгө оруулалтаар ирсэн 188,798.8 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, 123,032.3 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу шилжүүлснээр үндсэн хөрөнгийн жилийн эцсийн үлдэгдэл 506,614.6 мянган төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 159,426.2 мянган төгрөгөөр өссөн нь тайланд үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 862,106.8 мянган төгрөг, нийт зарлагыг 862,106.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тухайн жилд Эрүүл мэндийн даатгалын сангаас 773,175.6 мянган төгрөгийн, өөрийн орлогоос 6,000.0 мянган төгрөгийн, нийт 779,175.6 мянган төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 782,312.5 мянган төгрөг буюу 90.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Эмнэлгийн тусламж үйлчилгээ					
71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
80302	Нэг иргэнд ноогдох нормативаар	721,682.8	721,682.8		100.0%
81603	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	140,424.0	60,629.7	-79,794.3	43.2 %

НИЙТ	862,106.8	782,312.5	-79,794.3	90.7 %
-------------	------------------	------------------	-----------	---------------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 33,159.5 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилагдсан ирсэн. Гэрэл цахилгаан 2,798.5 мянган төгрөг, түлш халаалт 26,795.0 мянган төгрөг, цэвэр усны төлбөр 540.0 мянган төгрөг, урсгал засвар 3,000.0 мянган төгрөгийн зардлуудад зарцуулж 25.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	ЭМТ-ийн барилгын доод давхрын дотор талын засвар	5,000.0	5,000.0
ДҮН			5,000.0	5,000.0

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Отгон сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүлд аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Отгон сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 03 дугаартай албан тоотгоор ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 866,349.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,995.2 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Отгон сумын Эрүүл мэндийн төвийн шилэн дансны мэдээллийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Отгон сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,241.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 4,060.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсний мөрөөр үр дүнтэй ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,241.5	1	1,241.5	-
Зөвлөмж	1	4,060.8	1	4,060.8	
Нийт дүн	2	5,302.3	2	5,302.3	100%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 587,674.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 574,174.6 мянган төгрөгийн алдааг залруулан, 13,700.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага хүргүүлээгүй.

5.3 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ Төсвийн 13,700.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулахдаа анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй.

Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууны зарцуулалтын баримтыг бүрэн бүрдүүлээгүй	1	1,479.6			1	1,479.6	1	1,479.6				
Үндсэн хөрөнгийн тооллогын баримтыг бүрэн бүрдүүлээгүй	1	506,614.7			1	506,614.7	1	506,614.7				
Бараа материалын тооллогын баримтыг бүрэн бүрдүүлээгүй	1	66,080.3			1	66,080.3	1	66,080.3				
Дүн	4	574,174.6			4	574,174.6	4	574,174.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Зардлын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй	1	13,700.0					1	13,700.0				
Дүн	1	13,700.0					1	13,700.0				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН


СҮЛД АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

Г.ЗАЯА



Ц.АЛЛАНТУУЛ

ОГНОО: 2025-02-22